

**ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ОНООСОН НЭРЭЭС
ОНООСОН НЭР ДАХИН ҮҮСЭХ ЗҮЙ ТОГТОЛ**

Ж.Сэржээ¹

Ц. Сувд²

Аливаа хэлний оноосон нэр нь тухайн хэлнийхээ нэрийтгэл нэрээс, эсвэл өөр нэгэн гадаад хэлний үгээс бүтдэг. Энэ бол оноосон нэр үүсэх нэгэн арга юм. Түүнээс гадна нэгэнт оноосон нэр болоод хэвшчихсэн нэрийг дахин өөр зүйлийг нэрлэх нэр болгон хэрэглэх бас нэгэн арга байна. Өөрөөр хэлбэл нэгд, нэрийтгэл нэрээс үүсэх, хоёрт, оноосон нэрээс үүсэх гэсэн хоёр үндсэн аргаар оноосон нэр үүсдэг ажээ.

Оноосон нэрийн нэгэн төрөл нөгөөдөө шилжин хэрэглэгдэх ёс аль ч хэлэнд байдаг түгээмэл үзэгдэл юм. тухайлбал хүний нэр газар усны нэр, хот суурины нэр болж болно. Жишээлбэл Сүхбаатар гэдэг хүний нэр Сүхбаатар аймгийн нэр, бас Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотын нэр болсон байна. Мөн газар усны нэр улс, хот, суурин газар, засаг захиргааны нэгжийн нэр, овгийн нэр нь Алтай, Хөвсгөл, Орос, Монгол, Улаанбаатар, Дархан-Уул, Зүүнбаян, Бээжин, Дарьганга гэх мэтээр хүний нэр болон хэрэглэгддэг ба энэ үзэгдлийг зарим эрдэмтэд “оноосон нэрийн хоёр дахь хувь заяа” хэмээн нэрлэсэн нь ч бий. Ер нь орчин цагийн монгол хэлэнд оноосон нэр үүсэх арга, зүй тогтлыг нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд бид энэ удаа бусад төрлийн оноосон нэрээс хэрхэн хүний нэр болгон хэрэглэж байгааг тодорхой баримт түшин өгүүлэх зорилго тавьсан билээ.

Монголын нүүдэлчид эх болсон байгаль дэлхий, газар нутагтайгаа хүйн холбоотой амьдарч, уул усаа өөрсдийн амьдралын үндэс хэмээн үзэж, мөнх хөх тэнгэрийн нэгэн адил эртнээс шүтэн биширч, хайрлан хамгаалж ирсэн билээ. Тийм ч учраас нутаг орныхоо уул усыг хүндэтгэн, лус савдгийг нь аргадан овоо босгож тахилга үйлдсээр ирсэн зан үйл эртний бөө мөргөлөөс эхлэн өнөөгийн бурхны шашинд ч хадгалагдсаар иржээ. Монгол хүний нэрэнд уулын нэр, нуурын нэр, гол мөрний нэр маш олон байгаагаас гадна аймаг сум, хотын нэр, овгийн нэрээр ч нэрлэсэн нэр байдаг. ОХУ-ын эрдэмтэн Е.В.Сундуева “Энгийн оноосон нэр үүсэх аргуудын нэг нь оноосон нэрийн нэг төрлөөс нөгөөд шилжих процесс юм” /Онимизация онимов/ гээд “Монгол хүний нэрийн дунд газар усны нэр, угсаатны нэр, од тэнгэрийн эрхэсийн нэрээс гаралтай нэр тохиолддог” гэж бичсэн байна /1:37/.

1. Уулын нэрээр нэрлэсэн нэр. Монголчууд эрт дээр үеэс нутаг орныхоо нөмөр нөөлөг дор түүний ан амьтан, ургамал жимсийг нь хэрэглэж амьдарч ирэхдээ уул хангайгаа дээдлэн хүндэлж, хүнчлэн шүтэж ирсэн түүхтэй. Ийм ч учраас монгол даяар

¹ Доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

алдартай том уул нуруудын нэрээс эхлэн тухайн орон нутгийн хэмжээнд нь л хүмүүс мэддэг жижиг уулсын нэр хүртэл монгол хүний нэрэнд орсон байдаг. Тухайлбал монгол орны баруунаас өмнө хил хүртэл 1500 км үргэлжлэн тогтсон Алтайн уулсын нэрээр нэрлэсэн олон арван хүний нэр байна. *Алтай* (398), *Алтайбаатар* (120), *Алтайбаяр* (7), *Алтайсүмбэр* (5), *Алтайхан* (5), *Алтайжар* (3), *Алтайбүрэн* (3), *Амар-Алтай* (3), *Алтайбатхүү* (1), *Мөнх-Алтай* (1), *Мөнгөн-Алтай* (1), *Цагаан-Алтай* (1), *Энх-Алтай* (1), *Булган-Алтай* (1), *Баян-Алтай* (1), *Идэр-Алтай* (1), *Буян-Алтай* (1), *Нуур-Алтай* (1), *Эр-Алтай* (1), *Баяр-Алтай* (1), *Амар-Алтай* (1) *Даян-Алтай* (1), *Алтайбаянгол* (1), *Алтайбилэг* (1), *Алтайбулаг* (1), *Алтайбуян* (1), *Алтайдэлгэр* (1), *Алтайжаргал* (1), *Алтайжаргалант* (1), *Алтайжун* (1), *Алтайзоос* (1), *Алтаймаа* (1), *Алтаймөнгөө* (1), *Алтайнай* (1), *Алтайнбаяр* (1), *Алтайн-Өлзий* (1), *Алтайнутаг* (1), *Алтайнхүү* (1), *Алтайнэрдэнэ* (1), *Алтайнямбуу* (1), *Алтай-Од* (1), *Алтай-Оргил* (1), *Алтай-Өлзий* (1), *Алтайрагчаа* (1), *Алтайсаруул* (1), *Алтайсүмбэн* (1), *Алтайсүмбэнхүү* (1), *Алтайсэд* (1), *Алтайхорол* (1), *Алтайцэцэг* (1), *Алтайшагай* (1), *Алтай-Эрдэнэ* (1) гэсэн нэр өнөөгийн монголчуудын дунд хэрэглэгдэж байна. Хаалтан доторхи тоо нь тухайн нэрийн давтамж буюу тэрхүү нэрээр нэрлүүлсэн хүний тоо болно. Эндээс харвал Алтай хэмээх нэр маань ихэвчлэн нийлмэл нэрийн эхний хэсэгт нь орж байгаа бөгөөд олонх нь нэг давтамжтай нэр байна.

Монгол орны төв хэсэгт 700 км үргэлжилсэн Хангайн нурууны нэрээс *Хангай* (7), *Баялагхангай* (1), *Хангайннуруу* (1), *Хатанхангай* (1), *Хангайдэлгэр* (1), *Хангайдаваа* (1), *Хангайжун* (1), *Хангайнбаатар* (1), *Хангайноров* (1), *Хангайнчимэг* (1), *Хангайням* (1), *Хангайрашаан* (1), *Хангайтүвшин* (1), *Хангайчингэс* (1) гэсэн нэр үүссэн байна. Хангайхүү, Хангайсайхан, Хангайбаян гэх мэтийн нэрүүд байдаг боловч цөөн 1-9 давтамжтай нэрсийн дотор тохиолдохгүй байгаагаас үзвэл тэдгээр нэр 10-аас дээш давтамжтай байгаа ажээ.

Монгол орны төв хэсэгт Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгийн нутгийг дамнан орших 250 км үргэлжлэн тогтсон Хэнтийн нурууны нэрээс *Хэнтийхүү* (4), *Бууралхэнтий* (1), *Хэнтийбаяр* (1), *Хэнтийхан* (1), *Хэнтийбаатар* (1), *Хэнтэй* (1) гэсэн нэр үүсэн хэрэглэгдэж байна. Монгол орны дээрх гурван их нуруунаас гадна олон уул, хайрхны нэр хүний нэр болон хэрэглэгдсээр ирсэн байна. Тухайлбал *Булгангэрэл* (7), *Булганцэнгэл* (7), *Булганчулуун* (7), *Булганхан* (6), *Булганхангай* (3), *Булгануул* (2), *Булганбилэг* (2) гэдэг нэрс бол Булган, Хөвсгөл, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Ховд, Баянхонгор, Увс, Өвөрхангай аймгуудын нутагт байдаг Булган нэрт уулсын нэрээс гаралтай юм.

Цагаан-Уул (8), *Баянзүрх* (7), *Их-Уул* (6), *Бүрэнхаан* (3), *Жаргалантуул* (3), *Өлзийтуул* (3), *Сонгинотуул* (1), *Сонгино* (1), *Адуунчулуун* (3), *Олонбулаг* (2), *Хандгайт* (1), *Тээл* (2), *Баттээл* (1), *Энхтээл* (3), *Ариунтээл* (1) гэсэн уул усны нэр бол монгол орны нутагт өргөн дэлгэрсэн түгээмэл нэр учир аль аймгийн ямар уулын нэрээр нэрлэснийг нь хэлэхэд хэцүү.

Мөнххайрхан нэртэй хүн 6 байна. Мөнххайрхан бол Монгол Алтайн нуруунд орших 4204 м өндөр мөнх цаст уул билээ. *Саян* (6), *Саянцэцэг* (3), *Саян* (2), *Мөнхсоён* (1) нэр бол монгол орос хоёр улсын хилийн заагаар орших урт нурууны нэр ба энэ нурууг зарим ном зохиол, газрын зурагт Соёны нуруу гэх нь бий. Зүүн Саяны 3491 м өндөр оргил Мөнхсарьдаг уул Хөвсгөл аймгийн нутагт байдаг. *Хантайшир* (5), *Нямтайшир* (2), *Мөнхтайшир* (1), *Билгүүнтайшир* (1), *Булгантайшир* (1) бол Говь-Алтай аймгийн нутагт байх Алтайн нурууны салбар нэгэн их уул Хантайширын

нурууны нэрээс гаралтай. *Байтаг* (4) бол Ховд аймгийн Булган сумын нутагт буй хилийн уулын нэрээс гаралтай. *Сутайбаяр* (1), *Сутайбилэг* (1), *Сутай-Очир* (1), *Сутайхайрхан* (1), *Сутайхүү* (1), *Мөнхсутай* (1) гэдэг нэрс бол Ховд, Говь-Алтай аймгийн нутгийн заагт орших 4090 м өндөр Сутай уулын нэрээс үүсэлтэй. *Суваргахайрхан* (1) бол Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших Хангайн нурууны нэгэн салбар, Орхон голын эх, 3179 м өндөр Суварга хайрхан уулын нэрээр нэрлэсэн байна.

Хархираа (1) бол Увс аймгийн Тариалан сумын нутагт байх 3221 м өндөр уулын нэрээс гаралтай. *Булнай* (2), *Булнайхүү* (1), *Буланай* (1) гэдэг нэр Хөвсгөл, Завхан аймгийн нутгийн заагт орших оргил нь 2613 м өндөр Булнайн нурууны нэрээс гаралтай. *Өндөрхаан* (2) гэсэн нэр нь Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших 1664 м өндөр уулын нэрээс, эсвэл тэр уулаар нэршсэн Хэнтий аймгийн Өндөрхаан хотын нэрээс үүсэлтэй. *Ханхөхий* (2), *Мөнххөхий* (1), *Хөхийсайхан* (1), *Хөхий* (1) гэдэг нэрс бол Увс аймгийн Цагаанхайрхан сумын нутагт орших Хан хөхийн нурууны (оргил нь 2591м өндөр) нэрээс гаралтай. *Ээжхайрхан* (1) гэдэг нэр бол Говь-Алтай аймгийн Цогт сумын нутаг, Алтайн өвөр говьд орших 2274 м өндөр өвөрмөц сонин тогтоцтой Ээж хайрхан уулын нэр, *Хянган* (1) гэдэг бол Монголын зүүн зах, хятад монгол хоёр улсын хил орчим орших Хянганы нурууны нэр байна. *Баатархайрхан* (1)- Ховд аймгийн төвийн урдхан орших Баатархайрхан уулын нэр. Баатархайрхан уулын нэрийг урьд нь Талын улаан хэмээн нэрлэдэг байжээ. 1912 оны 8-р сарын 7-нд Ховд хотыг манжийн ноёрхлоос чөлөөлсний дараа монгол цэргийн гол хүч байрлаж байсан энэ уулыг Баатархайрхан хэмээн нэрийдсэн аж.

2. Нуурын нэрээс гаралтай нэр: Монголын ард түмэн эх орныхоо нуур, гол мөрөн, булаг усыг эх, ээж хэмээн хүндлэн хайрлаж тэдгээрийн нэрийг ихэвчлэн охин үрдээ өгч байсан уламжлал одоо хүртэл хэвээрээ хадгалагдан үлдсэн байна.

Монгол орны сувд эрдэнэ болсон 262.4 м гүн цэнгэг уст Хөвсгөл нуурын нэртэй хүн олон байдаг. Үүнд: *Хөвсгөл* (51), *Хөвсгөлсайхан* (1), *Дарханхөвсгөл* (1), *Хөвсгөлмөрөн* (1), *Хөвсгөлболор* (1), *Хөвсгөлдаваа* (1), *Тунгалаг-хөвсгөл* (1) гэдэг нэрсийг дурдаж болно. Түүнчлэн дэлхийн хамгийн гүн цэнгэг уст нуур Байгал нуурын нэрээс *Байгалдалай* (7), *Отгонбайгал* (7), *Байгальдалай* (6), *Дөлгөөнбайгаль* (5), *Байгалнуур* (2), *Байгалтуул* (2), *Байгаль-Ангар* (1) гэдэг нэрс үүсчээ.

Монголын хамгийн том талбайтай (3350 км²) Увс нуурын нэрээр нэгэн аймгийг нэрлэдгээс гадна *Увс* (1), *Увсболд* (1) гэсэн хүний нэр болгосон байна. Манай улсын зүүн хязгаарын томоохон нуур 615 км кв. талбайтай Буйр нуурын нэрээс *Буйр* (8), *Бойр* (2), *Буйраа* (2), *Мөнхбуйр* (3), *Ариунбуйр* (1), *Ууганбуйр* (1), *Энхбуйр* (1), *Батбуйр* (2), *Буйрдалай* (2), *Буйрнуур* (2), *Буйрцэнгэг* (1) гэдэг нэрс үүсэн хэрэглэгдэж байна. Завхан аймгийн Тэлмэн, Нөмрөг сумын нутгийн заагт орших 194 км кв. талбай бүхий Тэлмэн нуурын нэрээс *Тэлмэнсайхан* (4), *Гантэлмэн* (3), *Тэлмэнбаатар* (3), *Тэлмэнжаргал* (2), *Тэлмэнтөгс* (2), *Зэстэлмэн* (1), *Тэлмин* (1), *Тэлмэндарь* (1), *Тэлмэнзаяа* (1), *Тэлмэнноров* (1), *Тэлмэнпүрэв* (1), *Тэлмэнсүрэн* (1), *Тэлмэнтүяа* (1), *Тэлмэнхаан* (1), *Тэлмэнцэцэг* (1), *Тэлмэн-)* *Эрдэнэ* (1) гэсэн 16 нэр үүссэн байна. Мөн Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт буй 61 км² талбайтай Ойгон нуурын нэрээс *Ойгон* (5), *Ойгонжаргал* (3), *Алтан-Ойгон* (2), *Ойгонбаяр* (2), *Ойгонгэрэл* (2), *Ойгонжав* (2), *Ойгонзаяа* (2), *Ойгонтүмэн* (2) гэсэн нэрс үүссэн байна. Түүнчлэн *Өгийдалай* (7) - Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт буй Өгий нуурын нэрээс, *Жугнай* (3) гэдэг нэр Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт буй Жугнай нуурын нэрээс, *Гангануур* (2),

Отгонгангамаа (1), Ганганнуур (1) гэдэг нэрс Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дахь Ганга нуурын нэрээс, Ачитнуур (1) гэдэг нэр бол Баян-Өлгий, Увс аймгийн нутгийн заагт орших 297 км² талбай бүхий Ачит нуурын нэрээс, Цэцэгнуур (2) гэдэг нэр бол Ховд аймгийн Цэцэг сумын нутагт буй Цэцэг нуурын нэрээс, Гүнжнуур (1)-Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дахь Гүн нуурын нэрээс тус тус үүссэн хүний нэрс болно.

3.Мөрөн голын нэрээр нэрлэсэн: Монгол хүний нэрийн санд мөрөн голын нэр ихээхэн түгээмэл хэрэглэгддэгийн дотроос Сэлэнгэ, Туул голын нэр хамгийн олон юм. Тухайлбал, Сэлэнгэ нэртэй 2632 /Сэлэнгээ 128/ хүн байгаагаас гадна Мөнгөнсэлэнгэ (8), Пүрэвсэлэнгэ (8), Сэлэнгэтуяа (8), Тунгалагсэлэнгэ (7), Хатансэлэнгэ (7), Сэлэнгэжаргал (6), Эрдэнэсэлэнгэ (5), Баянсэлэнгэ (4), Болорсэлэнгэ (4), Намнансэлэнгэ (4) - Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт буй Намнангийн нурууны өмнүүр Сэлэнгэ мөрөн урсан өнгөрдөг. Иймд энд төрсөн хүний нэр байж болно. Оюунсэлэнгэ (3), Сэлэнгэдорж (3), Сэлэнгэсүлжээ (3), Сэлэнгэцэцэг (3), Намуунсэлэнгэ (2), Өргөнсэлэнгэ (2), Сувдансэлэнгэ (2), Сэлэнгэдалай (2), Сэлэнгэдэлгэр (2), Сэлэнгэтамир (2), Сэлэнгэтогтох (2), Сэлэнгэтуул (2), Сэлэнгэ-эрдэнэ (2), Ариунсэлэнгэ (1), Шинэсэлэнгэ (1), Баасансэлэнгэ (1), Бассэлэнгэ (1), Батсэлэнгэмаа (1), Булгансэлэнгэ (1), Буянтсэлэнгэ (1), Галсэлэнгэ (1), Дархансэлэнгэ (1), Дөлгөөнсэлэнгэ (1), Дэлгэрсэлэнгэ (1), Дэмидсэлэнгэ (1), Ихсэлэнгэ (1), Жавзансэлэнгэ (1), Мөнхсэлэнгэ (1), Нарансэлэнгэ (1), Одсэлэнгэ (1), Сэлэнгэамьдрал (1), Сэлэнгэбат (1), Сэлэнгэбүтэд (1), Сэлэнгэбуян (1), Сэлэнгэдолгио (1), Сэлэнгэзаяа (1), Сэлэнгэ-Оргил (1), Сэлэнгэ-Очир (1), Сэлэнгэ-ундрам (1), Үржсинсэлэнгэ (1), Үүлэнсэлэнгэ (1) гэсэн нэрс бүгд монгол улсын хамгийн их уст, 992 км урт том мөрөн Сэлэнгийн нэрээс гаралтай байх ба Сэлэнгэ мөрний нэрээр бас нэгэн аймгийг ч нэрлэсэн байдаг.

Хэнтийн нуруунаас эхлэн Улаанбаатар хотын дундуур урсан өнгөрч Орхон голд цутгадаг 819 км урт Туул голын нэрээс үүссэн “Туул” гэсэн дан нэртэй 3113 хүн байгаагаас гадна Туулсүрэн (9), Амартуул (7), Буянтуул (7), Туултуяа (6), Дархантуул (7), Бямбатуул (6), Дэлгэртуул (6), Сайхантуул (6), Хантуул (6), Шинэтуул (6), Туултуяа (6), Бүжинтуул (5), Мөнтуул (5), Мягмартуул (5), Баасантуул (4), Мянгантуул (4), Сансартуул (4), Сонгинотуул (4)- Улаанбаатар хотын орчимд Сонгино хайрхан уулын өмнүүр Туул гол урсан өнгөрнө. Сонгино гэдэг нь энэ уулын нэр юм. Сэргэлэнтуул (4), Түмэнтуул (4), Цэцэнтуул (4), Баатартуул (3), Мөрөнтуул (3), Лхагватуул (3), Өргөнтуул (3), Тунамалтуул (3), Туулчимэг (3), Ундрахтуул (3), Агьтуул (3), Цэцэгтуул (3), Чулуунтуул (3), Бадамтуул (2), Гэрэлттуул (2), Жаргалтуул (2), Идэртуул (2), Мөнхтуул (2), Бүрэнтуул (2), Оргилтуул (2), Пүрэвтуул (2), Соронзонтуул (2), Төмөртуул (2), Туултунгалаг (2), Цолмонтуул (2), Цэнгэлтуул (2), Гоётуул (2), Чаминтуул (2), Шижиртуул (2), Энхтуул (2), Эхтуул (2), Гүнтуул (1), Тамиртуул (1), Түргэнтуул (1), Үнэнтуул (1), Уяхантуул (1), Хангайтуул (1), Хангалтуул (1), Хүүхэнтуул (1), Цагаантуул (1), Энхтуулмаа (1), Энэбиштуул (1), Яруутуул (1), Гэгээнтуул (1), Долгионтуул (1), Есөнтуул (1), Ижилтуул (1), Осортуул (1), Осгонтуул (1), Оюутуул (1), Сонинтуул (1), Туулбатсүх (1), Туулбазар (1), Туулбаян (1), Туулбаясгалан (1), Туулбилэг (1), Туулбилэгт (1), Туулгазар (1), Туулгол (1), Туулгуа (1), Туулгэрэл (1), Туулдохио (1), Туулдөлгөөн (1), Туулжаал (1), Туулжаргал (1), Туулжсин (1), Туулнаран (1), Туулпүрэв (1), Туулсайхан (1), Туултамир (1), Эрхтуул (1), Туултогтох (1), Туулхишиг (1) гэсэн 74 нэр хэрэглэгдэж байна.

Хэнтийн нуруунаас эх авч 1090 км урт урсан БНХАУ-ын нутаг Далай нуурт цутгадаг Хэрлэн голын нэрээс үүссэн Хэрлэн нэртэй 607 хүн байгаас гадна Энххэрлэн (9), Хэрлэнбат (8), Хэрлэн-Ундрах (9), Хэрлэнхүү (7), Хэрлэнсайхан (6), Хэрлэнболд (5), Хэрлэнгуа (5), Болорхэрлэн (4), Хэрлэнболор (4), Хэрлэнтөгс (4), Хэрлэнцог (4), Хэрлэнчулуун (4), Хэрлэнжаргал (3), Хэрлэнмөнх (3), Хэрлэнсүх (3), Хэрлэнтамир (3), Хэрлэнцацрал (3), Мөнгөнхэрлэн (4), Отгонхэрлэн (4), Оюунхэрлэн (3), Багахэрлэн (2), Намуунхэрлэн (2), Ундраххэрлэн (2), Батхэрлэн (2), Хатанхэрлэн (2), Хэрлэнбаян (2), Хэрлэнбуян (2), Хэрлэнсүвд (2), Хэрлэнсүрэн (2), Хэрлэнтулга (2), Хэрлэнурсгал (2), Арвинхэрлэн (1), Гангахэрлэн (1), Ганхэрлэн (1), Дэлгэрхэрлэн (1), Иххэрлэн (1), Нямхэрлэнхэрлэн (1), Тунгалагхэрлэн (1), Цэвээнхэрлэн (1), Цэнхэрхэрлэн (1), Шинэхэрлэн (1), Хэрлэнбуд (1), Хэрлэнбулган (1), Хэрлэнбямба (1), Хэрлэнговь (1), Хэрлэнгол (1), Хэрлэнгоо (1), Хэрлэнгэрэл (1), Хэрлэндаваа (1), Хэрлэндаваадорж (1), Хэрлэндорж (1), Хэрлэндөлгөөн (1), Хэрлэнжавзан (1), Хэрлэнзагас (1), Хэрлэнзориг (1), Хэрлэнзул (1), Хэрлэн-Од (1), Хэрлэниүрэв (1), Хэрлэнтал (1), Хэрлэнтогос (1), Хэрлэнтооно (1), Хэрлэнтөвшин (1), Хэрлэн-Ундарга (1), Хэрлэнхүү (1), Хэрлэнхүүхэн (1), Хэрлэнцогт (1) гэсэн 56 нэр үүсэн хэрэглэгдэж байна.

Хангайн нуруунаас эхэлж 1124 км урсаж Сэлэнгэ мөрөнд цутгадаг, монголын хамгийн урт гол Орхон голын нэрээс үүссэн Орхон нэртэй 663 хүн байгаагаас гадна Орхонхүү (9), Орхонзаяа (7), Орхонтөгс (6), Орхонтулга (5), Орхон-Эрдэнэ (4), Орхонбайгаль (3), Орхонболд (3), Орхонгэрэл (3), Орхон-Урсгал (3), Орхонхишиг (3), Орхончулуун (3), Энх-Орхон (3), Бат-Орхон (2), Ган-Орхон (2), Орхонгол (2), Орхонгуа (2), Орхондалай (2), Орхонзул (2), Орхонжигүүр (2), Орхонлхам (2), Орхонмөрөн (2), Орхонсайхан (2), Орхонтогтох (2), Орхонцогт (2), Энх-Орхон (2), Эрдэнэ-Орхон (2), Ариун-Орхон (1), Орхонголынжаргал (1), Орхондүү (1), Орхондэлгэр (1), Орхонзориг (1), Орхонмаа (1), Орхонмөнх (1), Орхоннамир (1), Орхоннэмэх (1), Орхон-Отгон (1), Орхон-Өлзий (1), Орхонсараа (1), Орхонсүвд (1), Орхонтал (1), Орхонтэнгэр (1), Орхонханд (1), Орхонцолмон (1), Орхончимид (1), Орхоншүр (1), Орхон-Эрдэнэ (1), Цогт-Орхон (1) гэсэн 47 нэр үүсгэн хэрэглэж байна.

Хэнтий нуруунаас эх авч 445 км урсаад ОХУ-ын Ингэдэйд цутгадаг Онон голын нэрээс үүссэн Онон нэртэй 875 хүн байгаагаас гадна Ононжаргал (9), Энх-Онон (9), Ононзул (7), Ононсайхан (6), Мөнх-Онон (5), Ононгуа (4), Онондарь (4), Онон-Эрдэнэ (4), Ононболд (3), Ононтөмөр (3), Баян-Онон (2), Ононбайгаль (2), Ононбилэг (2), Ононзаяа (2), Ононтамир (2), Ононтулга (2), Онон-үжсин (2), Ононхатан (2), Ононцацрал (2), Саруул-Онон (2), Батонон (2), Дөлгөөн-онон (1), Дэлгэр-Онон (1), Ононгол (4), Ононбадамцэцэг (1), Ононболор (1), Ононванчиг (1), Ононгэрэл (1), Онондолгион (1), Онондуурлиг (1), Онондэлгэр (1), Ононмаа (1), Ононмандах (1), Ононмөр (1), Ононнамсрай (1), Ононнуур (1), Ононтал (1), Ононтөгс (1), Ононтрейд (1), Ононтул (1), Ононурсгал (1), Ононхангай (1), Ононцацраг (1), Онончулуун (1), Төвшин-Онон (1), Энх-Онон (1) гэсэн 46 нэр үүсгэн хэрэглэж байна. Монгол орны олон зуун гол мөрнөөс эдгээр таван голын нэр монгол хүний нэрэнд хамгийн өргөн хэрэглэгддэг юм. Учир нь Онон, Хэрлэн, Туул гол бол эртнээс нүүдэлчин монголчуудын өлгий нутаг болж “гурван голын монголчууд”, “гурван голын сав газар” хэмээн хэлэлцэгдсээр ирсэн бол Сэлэнгэ мөрөн манай хамгийн их уст том мөрөн бөгөөд Байгаль нуурыг усаар тэтгэх гол цутгал нь болж байдаг. Харин Орхон гол бол эрт дээр үеэс Төв Азийн нүүдэлчдийн төр улсаа байгуулж оршин амьдарч байсан гол төв нутаг бөгөөд өнөө хүртэл “Мянган дурсгалт Орхоны хөндий” хэмээн нэрлэгдсээр байна.

Дээрх таван их голоос гадна бусад голуудын нэр ч цөөнгүй тохиолдоно. Үүнд: Булнай нуруунаас эх авч 568 км урсаад Увс нуурт цутгадаг Тэсийн голын нэрээс *Болортэс* (8), *Тэс* (4), *Тэсмөрөн* (3), *Тэсээ* (3), *Энхтэс* (3), *Анхтэс* (2), *Баянтэс* (2), *Мөнгөнтэс* (2), *Номинтэс* (2), *Тэсхуяг* (2), *Ариунтэс* (1), *Ихтэс* (1), *Тэссайхан* (1), *Тэсмэнд* (1), *Тэстамир* (1), *Хартэс* (1), *Цолмонтэс* (1), *Цэлмэгтэс* (1), *Чулуунтэс* (1) хэмээн 19 нэр үүсгэн 40 хүнийг нэрлэсэн байна. Архангай аймгийн нутагт Хангайн нуруунаас эхэлж Орхон голд цутгадаг Тамирын голын нэрээс *Булгантамир* (8), *Тамирмаа* (8), *Тамирмөнх* (6), *Ундрахтамир* (5), *Хантамир* (5), *Цэнгэлтамир* (4), *Сэргэлэнтамир* (3), *Хостамир* (3)-Тамирын гол хоёр өөр газраас эх авч Хойд Тамир, Урд Тамир хэмээн нэрлэгдэж явсаар Батцэнгэл сумын төвийн ойролцоо ирж нийлэн урсаж Тамир нэртэйгээр Өгий нуурын ойролцоо ирж Орхон голд цутгадаг. Хостамир гэдэг нэрийн утга үүнд оршино. *Намуунтамир* (2), *Оргилтамир* (2), *Өргөнтамир* (2), *Тамирмөрөн* (2), *Тулгатамир* (2), *Тунгалагтамир* (2), *Тэгштамир* (2), *Тэнүүнтамир* (2), *Бадамтамир* (1), *Булгантамир* (1), *Дөлгөөнтамир* (1), *Долгионтамир* (1), *Дүүрэнтамир* (1), *Жанцантамир* (1), *Тамиргол* (1), *Ижилтамир* (1), *Ихтамир* (1)- ийм нэртэй сум Архангай аймагт байдаг. *Цагаантамир* (1), *Цолмонтамир* (1), *Цэлмэгтамир* (1), *Уяхантамир* (1), *Хөхтамир* (1), *Хунтамир* (1), *Цэнгэгтамир* (1), *Тамиртулга* (1), *Тамиртушиг* (1) гэсэн 34 нэр үүсгэж 75 хүнийг нэрлэсэн байна. Түүнчлэн Тамир гэсэн 1973 нэр байгаагийн ихэнх нь энэхүү голын нэртэй холбоотой гэж болно.

Баян-Өлгий аймгийн нутагт Алтайн нуруунаас эхэлж Ховд голд цутгах Буянт голын нэрээс *Тунгалагбуянт* (7), *Буянтгол* (2), Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Бага Хэнтий нуруунаас эх авч Туул голд цутгах Тэрэлжийн голын нэрээс *Ариунтэрэлж* (1), *Тэрэлжмаа* (1), Хэнтийн нуруунаас эх авч Орхон голд цутгадаг Ерөө (323 км урт) голын нэрээс *Ерөөхүү* (5), *Ерөөсайхан* (3), *Ерөөбаатар* (1), *Ерөөбадам* (1), *Ерөөгэрэл* (1), *Ерөөнэмх* (1), *Ерөөжав* (2) гэсэн нэр үүсгэн хэрэглэж байна.

Завхантуяа (1), *Завханбиш* (1), *Завханмаа* (1) гэсэн нэрс байгаа нь Завхан голын нэртэй холбоотой. Завхан голын нэрээр Завхан аймгийг бас нэрлэсэн ажээ. Завхан гол бол Хангайн нуруунаас эх авч Айраг нуурт цутгадаг 808 км урт манай орны томоохон голуудын нэг болно. *Тэрх* (2), *Ариунтэрх* (3), *Болортэрх* (2), *Дөлгөөнтэрх* (1) гэдэг нэрс нь Архангай аймгийн Хангай, Тариат сумын нутгаар урсаж Тэрхийн цагаан нуур (61 км² талбайтай)-т цутгах Хойд Тэрх, Урд Тэрх гэсэн хоёр голын нэрээс гаралтай хүний нэр юм. Цаашилбал *Арсай* (4)-Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ сумын нутагт буй голын нэрээс, *Онги* (4)- Хангайн нуруунаас эх авч Улаан нуурт цутгадаг 435 км урт голын нэрээс, *Агаржав* (3), *Агарцэцэг* (3) гэдэг нэрс нь Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын нутагт буй Агарын голын нэрээс, *Ангарбаяр* (2), *Ангаржав* (2), *Ангарзул* (2), *Ангарсүрэн* (2), *Ангартуяа* (2), *Ангар-Эрдэнэ* (2) -ОХУ-ын Байгаль нуураас эх аван урсдаг Ангар мөрний нэрээс, *Ганшишгэд* (3), *Шишгэдсайхан* (1), *Шишгэдмаа* (1), *Шишгэдмандал* (1), *Шишгэддэлгэр* (1) -Хөвсгөл аймгийн Дархадын хотгороос эх авч Енисей мөрөнд цутгах Шишгэдийн голын нэрээс, *Мөрөнжаргал* (3), *Мөрөнтуяа* (3), *Мөрөнхүү* (3) гэдэг нэрс нь Хөвсгөл аймгийн нутгаар урсах Дэлгэр мөрний нэрээс (энэ голыг нутгийн иргэд Мөрөн, Мөрөнгийн гол хэмээн нэрлэх ба энэ нэрээр аймгийнхаа төвийг нэрлэсэн байдаг билээ) гаралтай юм.

Улз (3), *Баян-улз* (1), *Улзмөрөн* (1), *Улзтунгалаг* (1), *Улзхүү* (1) гэсэн нэрс нь Хэнтий нуруунаас эх авч 428 км урсаад Хөх нуурт цутгах Улз голын нэрээс, *Ховдгол* (1), *Ховдбаатар* (3) гэдэг нэрс нь Алтайн нуруунаас эх авч Хар-ус нуурт цутгадаг 516 км урт Ховд голын нэрээс, *Чигэстэй* (3) нь Завхан аймгийн төв Улиастай хот дундуур

урсан өнгөрдөг Чигэстэй голын нэрээс, *Аригмаа* (2) гэдэг нэр бол Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутагт буй Аригийн голын нэрээс, *Сарандунай* (2), *Ичиндунай* (1) гэдэг нэр нь Европын Герман, Австри, Чех, Унгар, Югослав, Болгар, Румын, ОХУ-ын нутгаар 817 км урт урсан өнгөрч Хар тэнгист цутгадаг Дунай мөрний нэрээс, *Хануймандах* (2), *Хануйбаатар* (1), *Хануйжар* (1), *Хануйсүрэн* (1) гэдэг нэрс бол Хангайн нурууны араас эх авч Сэлэнгэ мөрөнд цутгадаг 421 км урт Хануй голын нэрээс, *Булгангол* (1), *Булганнева* (1) гэдэг нь Баян-Өлгий аймгийн Булган сум, Ховд аймгийн Булган сумын нутгаар урсдаг, Алтайн нуруунаас эх авдаг Булган голын нэрээс, *Ижилмөрөн* (1) нь Европын хамгийн урт (3530 км) мөрөн Волга мөрний (монголоор Ижил мөрөн) нэрээс, *Амур* (1), *Амурбаяр* (1), *Амурмөрөн* (1) хэмээх нэрс нь (монголоор Хар мөрөн гэдэг) Хайлаар орчмоос эхлэн 4440 км урсаж Агнуурын тэнгист цутгах Амур мөрний нэрээс, *Баянбайдраг* (1) -Хангайн нурууны өврөөс эхлэн 295 км урсаж Бөөнцагаан нуурт цутгах Байдрагийн голын нэрээс, *Халхынгол* (1)-Хянганы нуруунаас эхэлж, 233 км урсаж Буйр нуурт цутгах Халх голын нэрээс, *Хатанхараа* (1) гэдэг нэр бол Хангайн нуруунаас эхэлж Орхон голд цутгах 291 км урт Хараа голын нэрээс, *Шарынгол* (1)-Дархан хотын орчим Шарын голын уурхайн дэргэдүүр урсан өнгөрч Орхон голд цутгадаг Шарын голын нэрээс тус тус үүсэлтэй хүний нэрс юм. Дээр дурдсан цөөн давтамжит нэрээс гадна Сэлэнгэ 2632, Сэлэнгээ 128, Сэлэнгэмөрөн 116, Туул 3113, Онон 875, Орхон 663, Хэрлэн 607, Тамир 1973 гэх мэтээр олон давтамжтай түгээмэл нэр монголчуудын дунд өргөн хэрэглэгдэж байна.

Баянбуурал (2), *Баянхошуу* (2), *Чингэлтэй* (2), *Ихтэнгэр* (1) гэх мэтийн нэрс нь Улаанбаатар хот орчмын газрын нэрээс үүсэлтэй гэж хэлж болно. Мөн монгол хүний цөөн давтамжит нэрсийн дотор *Номхондалай* (2)-манай гаригийн хамгийн том далайн нэр, *Хэрлэнбарс* (1)-Дорнод аймгийн нутагт буй эртний Кидан улсын хотын үлдэгдэл балгасын нэр, *Гимлай* (3), *Гималай* (1)-Энэтхэг, Хятад, Балба улсын нутгийн заагт орших дэлхийн хамгийн өндөр уулс бүхий Гималайн нурууны нэр, *Дүнжингарав* (2)-Улаанбаатар хотын өмнө талд орших Богд уулын төвд нэр, *Алтановоо* (2)-Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших төрийн тахилгат уулын нэр, *Эрхүү* (7)-Соёны нуруунаас эх аван урсах ОХУ-ын Эрхүү мужийн нутаг дахь голын нэр, *Минжийнхангай* (1), *Минжинхангай* (4)-Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших их уулын нэр, *Ноёнхангай* (3)-Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дахь Ноён уулын нэрээс, *Тайхар* (6), *Тайхир* (2), *Баттайхар* (1), *Хантайхар* (1) гэдэг нэрс бол Архангай аймгийн Их Тамир сумын нутагт орших Тайхар чулууны нэрээс тус тус гаралтай нь илэрхий.

Бас Төвхөн (6), *Галба* (4), *Онгонцэцэг* (6), *Бэлэндалай* (6), *Энхлүн* (3), *Галуутай* (2), *Далт* (2), *Баярцээл* (2), *Загдал* (1), *Базарзагдал* (2), *Батганга* (1), *Ханжаргалант* (2), *Тамсагбулаг* (2), *Гандануул* (1), *Жанхай* (1), *Жанцанзаамар* (1), *Угтаалцогт* (1), *Төмөртэй* (1), *Мөнхдагшин* (1), *Базарбигэр* (1), *Цэнгэлхаан* (1), *Утай* (2), *Эгийндаваа* (1) гэх мэтээр уул даваа, ус гол, газар нутгийн нэрээс үүсэлтэй хүний нэр олон бий. Энэ талаар ОХУ-ын эрдэмтэн О.Ф. Золтоева “Газар зүйн объектуудын нэр нь хүний нэр үүсэх нэгэн үндэс болдог” гээд өнөөгийн монголчуудын дунд Орхон, Орхонтуул, Сэлэнгэ, Туул, Хөвсгөл, Хэрлэн зэрэг усны нэр, Баянхонгор, Бээжин, Дархан, Улаанбаатар зэрэг хот суурины нэр, Алтайсайхан, Аргалант, Баянзүрх, Отгонтэнгэр, Хэнтийхүү зэрэг уулын нэр байна” гэжээ /2:24/


4. Монгол улсын аймаг, хот, сумын нэрээр нэрлэсэн нэрийг ихэвчлэн тэнд төрсөн, тэр нутгийн уугуул хүн гэсэн утгаар өгсөн байдаг билээ. Үүнд: Аймаг, хотын нэрээс: Дарханзул (9), Дархантулга (8), Дарханбямба (7), Дархан-Эрдэнэ (7),

Дарханзаяа (6), Дарханням (5), Дархансүрэн (5), Дархантагс (5), Дарханхүү (5), Дарханбилэг (4), Дархан-Очир (4), Дарханхараа (3), Дархангэрэл (3), Дарханпүрэв (3), Дарханбямбаа (3), Дарханцоож (3), Дархантаг (3), Шинэдархан (1), Батдархан (3), Уугандархан (1) гэсэн нэрс бол 1961 онд байгуулагдсан Дархан хотын нэрээс гаралтай бөгөөд эдгээр хүмүүс бүгд Дархан хотод төрсөн хүмүүс байдаг.

Эрдэнэт-Од (9), Баянхонгор (8), Арвайхээр (4), Архангай (2), Зүүнбаян (2), Налайх (2), Багахангай (1), Төвэймаг (1), Даланзадгад (1), Дархан-уул (1), Дорнод (1)-бас Дорнодмаа гэсэн нэр нэг байгаа нь энэ аймгийн нэртэй холбогдоно. Есөнбулаг (1), Завхан (1), Мандалговь (1), Эрдэнэтсайхан (1), Хан-Эрдэнэт (1) -энэ хоёр нэр бол Эрдэнэт хотын нэрээс гаралтай. Бас БНХАУ-ын нийслэл Бээжин хотын нэрээс гаралтай Бээжин (80), Бээжинсүрэн (5), Бээжинбат (2), Бээжиндалай (2), Бээжинмаа (2), Мөнхбээжин (2), Бээжинбаатар (1), Бээжинбаяр (1), Бээжинболд (2), Бээжинсамдан (1), Бээжинсан (1), Бээжинсүх (1), Бээжинтогоо (1), Бээжинхангай (1) хэмээх нэр хэрэглэгдэж байна. Мөн Буриад улсын Хиагт хотын нэрээс Хиагтбаяр (1) гэдэг нэр бий болсон аж.

Мөн Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын нэрээр нэрлэсэн хүн байна.

Сумын нэрээс: Баянгол (9), Ханхонгор (8), Асгат (7), Цагаан-уул (8), Бөхмөрөн (7), Түвшинширээ (7), Дадал (5), Дарьганга (5), Онгон (5), Тосонцэнгэл (5), Баян-Өндөр (4), Бигэр (4), Зэлтэр (4), Тэшиг (4)-энэ нэрээс үүссэн Тэшигжсав (3), Тэшигжаргал (2), Тэшигмаа (2), Тэшигсүрэн (2) гэдэг нэр бас байна. Баянжаргалан (3), Могод (3), Ханбогд (3), Аргалант (2), Батишрээт (2), Баянбараат (2), Жаргалтхаан (2), Заамар (2), Улаанбадрах (2), Уулбаян (2), Халхгол (2), Хатгал (2), Баруунтуруун (1), Баяндун (1), Баянлиг (1), Баяннуурсум (1), Баянсум (1), Баянчандмань (1), Баянхайрхан (1), Бууцагаан (1), Дашинчилэн (1), Матад (1) -энэ нэрээс үүсэлтэй Матаддорж гэдэг нэр бас байна. Өмнөдэлгэр (1), Цэнхэрмандал (1), Шинэ-Идэр (1), Ханхбаяр (1)-Ханх сумын нэрээс гаралтай, Биндэрбаатар (1), Биндэрболд (1), Биндэрсайхан (1), Биндэрхуяг (1), Биндэрсүрэн (1), Биндэрчулуун (1), Батбиндэр (2) гэдэг нэрс бол Хэнтий аймгийн Биндэр сумын (энэ сумын нэр өөрөө уулын нэр) нэрээс гаралтай юм. Эдгээр аймаг сумын нэрс бол угтаа газар усны нэр бөгөөд газар усны нэрээр аймаг сумдыг нэрлэсэн нь нэгэнт тогтсон оноосон нэрийг дахин оноосон нэр болгон хэрэглэж байгаа хэрэг



Тэгвэл аймаг, сумын нэрээр хүнийг нэрлэж байгаа нь тэрхүү хоёр дахь удаагаа оноосон нэр болсон үгийг дахин гурав дахь удаагаа оноосон нэр болгож байгаа хэрэг юм. Жишээлбэл: “дарь” гэдэг үгээр Сүхбаатар аймгийн нэгэн уулыг, “ганга” гэдэг үгээр нэгэн нуурыг нэрлэж оноосон нэр болгосон байна. Энэхүү уул, нуур хоёрын нэрээр тэдний оршдог сумыг нэрлэж хоёр дахь удаа оноосон нэр болгожээ. Ингэж үүссэн сумын нэр тус улсад олон бий. Үүнд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын нэр нь Тосон гол, Цэнгэл нуурын нэрээс гаралтайг дурдаж болно. Тэгвэл Дарьганга, Тосонцэнгэл сумын нэрийг хүний нэр болгон хэрэглэсэн нь түүнийг гурав дахь удаагаа оноосон нэр болгож байгаа хэрэг юм. Ховд, Увс, Завхан, Сэлэнгэ, Хэнтий, Булган зэрэг уул усны оноосон нэрээр тухайн газар нутгийг хамаарах засаг захиргааны томоохон нэгж болох аймгийг нэрлэсэн нь гарцаагүй боловч, тэрхүү аймгийн нэрээр хүнийг нэрлэсэн гэж хараахан үзэж болохгүй. Харин тэдгээр уул усны нэрээр хүнийг шууд нэрлэсэн хэмээн үзэж болно. Тэгвэл Хөвсгөл нуурын нэрээр аймгийг нь ч нэрлэсэн,

хүнийг ч нэрлэсэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл Хөвсгөл нуурын оноосон нэрийг аймгийн нэр болгоод, тэрхүү аймгийн оноосон нэрээр хүнийг нэрлэсэн гэж болохгүй, хүний нэр аймгийн нэр хоёулаа нуурын нэрээс үүсэлтэй юм. Үүнээс үндэслэн аймаг, сумын нэрээр нэрлэсэн хүний нэр бүрийг гурав дахь удаагаа оноосон нэрээс үүссэн гэж үзэж хараахан болохгүй. Нэр зүйч Ж.Сэржээ “Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд таван хүүхэдтэй нэгэн айл хүүхдүүддээ Хөвсгөл, Аймаг, Тосон, Цэнгэл, Сум гэсэн нэр өгсөн” гэж өөрийн номдоо нэгэн сонирхолтой баримтыг дурдсан байдаг. /3:43/

Улс, үндэстний нэрээс: Юуны өмнө манай умард хөрш Орос улсын нэр олон тохиолддог. Тухайлбал: *Оросмаа* (6), *Оросхаан* (6), *Оросоохүү* (5), *Оросхүү* (4), *Бат-Орос* (3), *Оросбат* (2), *Ороссүх* (2), *Орсообаатар* (2), *Оросбаяр* (1), *Оросгомбо* (1), *Оросдаваа* (1), *Оросдагва* (1), *Оросдорж* (1), *Төмөр-Орос* (1), *Оросжаргал* (1), *Оросрэнцэн* (1), *Оросцэрэг* (1), *Оросоохүүхэн* (1), *Санжаа-Орос* (1), *Сүх-Орос* (1) гэсэн 18 нэрэнд орос гэдэг үг орж цөөн давтамжит нийлмэл нэр үүсгэснээс гадна Орос (56), Оросоо (169), Орсоо (382) байна. Монгол гэдэг үгээс *Шинэмонгол* (4), *Монголжийбуу* (3), *Монголзаяа* (3), *Монголтуяа* (3), *Эрэлхэгмонгол* (3), *Монголбуу* (2), *Монголсайхан* (2), *Монголсүрэн* (2), *Монголхүн* (2), *Монголицэцэг* (2), *Хүүхэнмонгол* (1), *Дэлгэрмонгол* (1), *Энхмонгол* (1), *Ихмонгол* (8) гэсэн 13 нийлмэл нэр үүсч 37 хүнийг нэрлэсэн байна. Цаашилбал *Хятад* (3), *Төвд* (2), *Түвдсүрэн* (5), *Тува* (2), *Туваа* (2), *Жагармаа* (3), *Жагарванчин* (1), *Жагаргадав* (1), *Жагаргардуу* (1), *Жагаргидав* (1), *Жагаргаду* (1), *Жагаргарав* (1), *Жагарганжидмаа* (1), *Жагаргэрэл* (1), *Жагардамба* (1), *Жагардашилхагва* (1), *Жагардулам* (1), *Жагаржалбуу* (1), *Жагаржамц* (1), *Жагаржанцан* (1), *Жагаржунай* (1), *Жагарнамнан* (1), *Жагарөлзий* (1), *Жагарсүм* (1), *Жагарсүх* (1) гэх мэтийн нэрс тохиолдож байна. Энэтхэг улсыг төвд хэлээр Жагар [rgya gar] гэдэг. Буддын шашны том хөлгөн судрууд эхлэхдээ Жагар гад дү [rgya gar skad du] ... Бод гад дү [bod skad du] ... буюу “Энэтхэгийн хэлээр.....”, “Төвдийн хэлээр...” хэмээн уг судрынхаа нэрийг санскрит, төвд хэлээр хамгийн эхний хуудасныхаа тэргүүнд бичдэг ёстой. Ийм хөлгөн судрыг нээн үзэхэд хамгийн түрүүнд **Жагар гад дү** гэдэг үгс нүднээ тусдаг. Дээр дурдсан Жагаргадав, Жагаргардуу, Жагаргидав, Жагаргадү гэсэн нэрсийг үүнтэй холбон тайлбарлах ёстой.

Халимаг (9), *Солонгос* (5), *Казах* (1), *Хасагаа* (4), *Хасагням* (5), *Хасагбаатар* (4), *Хасагхүү* (4) -монголчууд казахуудыг хасаг хэмээн нэрлэдэг, *Манжлхам* (2), *Манжмаа* (2), *Манжсүрэн* (2), *Манжхүү* (2) -1616-1911 он хүртэл 295 жил оршин тогтносон Манж Чин улсын нэр болон манж үндэстний нэрээс эдгээр нэр үүссэн ажээ. *Шинжаан* (1), *Уйгармаа* (4) -БНХАУ-ын Шинжаан уйгурын өөртөө засах орны нэр.

Монгол улсад амьдарч буй ястнуудын нэрээс: *Халхбаатар* (3), *Архалх* (2), *Халхбаяр* (2), *Халхсүрэн* (2), *Халхмаа* (1), *Халхмөнх* (1), *Халх-очир* (1), *Халхжав* (1), *Халхжаргал* (1), *Халхзул* (1), *Халххүү* (1), *Халх-Эрдэнэ* (1), *Баяд* (9), *Баядбаатар* (2), *Дөлгөөнбаяд* (1), *Дөрвөдхаан* (5), *Дүрвэд* (4), *Хотон* (1), *Хотонбаатар* (3), *Хошууд* (1), *Захчин* (2), *Урианхай* (2), *Ураанхай* (4), *Урайнхай* (1), *Батбуриад* (2), *Торгуудсүрэн* (1), *Өөлдхүү* (1), *Мянгаджав* (1), *Мянгадсүрэн* (1), *Хотгойд* (1), *Хамниган* (1), *Сартуул* (1), *Сарт-уул* (1), *Хорчин* (1), *Чантуухүү* (1), *Дархад* (1), *Цаатан* (7)гэх мэтийн нэр үүсэн хэрэглэгдэж байна. ОХУ-ын эрдэмтэн О.Ф. Золтеева “Монгол хүний нэрийн бүрэлдэхүүнд угсаатны бүлгүүдийн нэрээс үүссэн нэрс тохиолдог” гээд Монгол улсад: Монголжин, Оросхүү, Төвд, Үзэмчин, Чантуу, Буриадад: Татаар, Хальмаг, Халимагт: Цахр /Цахар/, Чечн /Чечень/ гэдэг нэр байгааг дурдахын сацуу ийм нэр төвд, орос зэрэг бусад ард түмний дунд ч байдаг гэжээ. /2:22/

Монгол овгийн нэрээс: Боржгин (2), Боржигон (1), Боржгино (1), Боржгин-Амар (1), Боржгинпүрэв (1), Тэлэнгэд (1), Баатад (1), Хаас (1) гэдэг нэр үүсчээ.

Оноосон нэрийг өөр өөрөөр бичсэнээс, тэр ч байтугай нэг үсгээс хамааран өөр нэр болдог гэдгийг байнга анхааралдаа байлгах хэрэгтэй. Бидний жишээ болгон авч байгаа нэрсийг ч ийнхүү алдаатай бичсэнээс нэг нэр хэд хэдэн нэр болж харагдаж байна. Тухайлбал энд жишээ болгон авсан боржигин гэдэг овгийн нэр гурван өөр бичлэгтэй байгааг анхаарсан биз ээ.

Ийнхүү нэгэнт үүсэн хэрэглэгдэж байгаа оноосон нэрийг дахин өөр төрлийн оноосон нэр болгон хэрэглэх нь орчин цагийн монгол хэлэнд түгээмэл байгаа зүй тогтолт үзэгдэл юм. Дээр дурдсан хүний нэрсээс гадна газар нутгийн олон нэрийн үүслийг энэхүү зүй тогтлоор тайлбарлаж болно. Тухайлбал монгол газар нутгийн нэр нь хүний нэрээс, ястан үндэстний нэрээс, амьтны нэрээс, ургамлын нэрээс, ашигт малтмалын нэрээс үүссэн олон зуун жишээ баримтыг дурдаж болно.

Ашигласан ном:

1. Сундуева Е.В. (2005) Пропримальное словообразование в современном монгольском языке. Улан-Удэ
2. Золтоева О.Ф. (2006) Онимическая лексика современного монгольского языка. Улан-Удэ.
3. Сэржээ Ж. (1992) Монгол хүний нэр. УБ.,
4. Монгол улсын нэвтэрхий толь.(2000) УБ.,

SUMMARY

Proper nouns of a language consist of the common noun or words of another language. It is a way of the formation of proper nouns. As well as, there is another way for formation of proper noun, which is the existing proper nouns are used as other new proper nouns. In other words, there are two main ways: firstly, formation from common nouns, secondly, formation from proper nouns.

It is common phenomenon that just a kind of proper nouns is used as another kind of proper nouns, in any language. For example, a personal name Sukhbaatar became the names either name of province or name of city. Also, place names, names of country or cities, names of territorial units are used as personal names such as Altai, Huvsgul, Oros (means Russia), Mongol, Ulaanbaatar, Darhan-Uul, Zuunbayan, Beijing, Daringana and so on.

It is necessary to study the principle and ways of formation of proper nouns in modern Mongolian in detail. Therefore, in this paper, we dealt with the usage of proper nouns as personal names, basing on the concrete materials. Thus, it became clear that the use of the existing proper nouns as new proper nouns is a common principle in modern Mongolian.